

## ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНЦГӨӨС ХЯТАД, ОРОСЫН ХАРИЛЦААГ АЖИГЛАХАД

*Писарёв\**

ЗХУ задарснаар Орос орон Ази, номхон далайн бүс нутагт бодлогоо шинээр боловсруулсан юм. Орос “социалист нөхөрлөлийн орнуудтай” харилцаагаа бодит байдалд нийцүүлэн засварласан бол харин 10 гаруй жил үргэлжилсэн сөргөлдөөний дараа Хятадтай харилцаагаа сайжруулах шаардлагатай болсон билээ.

Горбачёвын “перестройка” хэмээх бодлого хэрэгжсэнээр хоёр орны харилцаа хэвийн болсон боловч юуны түрүүнд аюулгүй байдал болон хил орчмын асуудлыг шийдвэрлэх тогтвортой хууль зүйн үндэс дутагдаж байсан юм. 1990-ээд оноос хоёр орны харилцаа сайжирснаар Орос орон аажмаар Ази, номхон далайн бүс нутагт нэгэн тулгуур болж хувирав.

Орос улс социалист лагерийн орнуудтай харилцаагаа “үзэл суртлын бус үндсэн дээр” өөрчлөн тогтоохын хамт “барууны” хэмээх урьд дайсагнаж байсан орнуудтай харилцаа тогтоох хийгээд Ази, номхон далайн бүс нутаг дахь шинэ гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ “хүчирхэг социалист гүрэн” хэмээх үзэл санаанаасаа татгалзан түүнийгээ “ардчилсан Орос орон” хэмээх үзлээр аажмаар сольж байна.

Энэхүү шинэ хандлагын дагуу Хятадтай маш нягт хамтын ажиллагаа тогтоов. Шинэ зуунд ОХУ түүхэндээ анх удаа Хятадтай харилцан итгэлцсэн үндсэн дээр стратегийн түншлэлийн харилцаа, АНУ-тай стратегийн шинэ харилцаа, Энэтхэг улстай /стратегийн/ харилцаа тогтоож, Японтой харилцах харилцаанд нь нааштай ахиц гарсан юм. Хятад улстай харилцах харилцаа нь Орос улсын Ази, номхон далайн бүс нутаг дахь гадаад харилцааны үндэс суурь нь болж байна. Нөгөөтэйгүүр Орос орон дангаараа Ази, номхон далайн бүс нутагт бүх талыг хамарсан аюулгүй байдал хамтын ажиллагааны талаар санал дэвшүүлсэн нь “АСЕАН”-ны гишүүн орнуудын эргэлзээг төрүүлсэн юм. 1994 онд дэвшүүлсэн “Аюулгүй нийгэм” хэмээх энэхүү төлөвлөгөөнд Ази, номхон далайн бүс нутгийн бүхий л орныг багтаасан боловч “холын санаа агуулсан” хэмээн олон улсын зүгээс эсэргүүцэлтэй тулгарсан юм.

Энэхүү нөхцөлд Орос улс аюулгүй байдал эдийн засгийн хамтын ажиллагааны системийг бий болгох шаардлагатай болсон билээ. Бүс нутгийн аюулгүйн байдлыг хангах энэхүү шинэ систем нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага юм.

1996 онд Хятад Орос, Казах, Киргиз, Таджик улсууд харилцан үл довтолцох хөрш орнуудын хил орчим цэргийн сургууль хийхгүй

\* Писарёв - Данзаний их сургуулийн Орос судлалын институтын Орос хэл, утга зохиолын тэнхмийн профессор

байх талаар хэлэлцээр хийв. Мөн хилээс 100 км дотогш цэргийн сургууль хийхдээ бие биендээ урьдчилан мэдэгдэх тухай тохиролцоонд хүрэв.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага байгуулагдсанаас хойш нэг жилийн дараа гишүүн таван орон хил залгаа 100 км нутгийг цэргийн бус бүс болгохоор тохирсон байна. 1999 онд Хятад Казахстан газар нутгийн асуудлаар гэрээ байгуулав.

Гишүүн 5 орон 2001 оны 7-р сард Шанхайн байгууллага байгуулагдсаныг зарласан ба тэдэн дээр Узбек улс нэгдсэнээр Шанхайн байгууллага 6 гишүүн орноос бүрдэх болов.

Улмаар Шанхайн гишүүн орнууд хамтран ажиллах гол зарчмаа тодорхойлохдоо юуны өмнө гишүүн орнуудын хилийн аюулгүй байдлыг хангах явдал гээд цаашид улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын зэрэг салбарт өргөжих хэтийн төлөвтэйг тэмдэглэсэн юм. Шанхайн хамтын байгууллагын гишүүн орнууд хүчин чармайлт гарган Төв Ази болон зүүн Азийн олон улсын байдалд санаа тавих болно гэдгээ мэдэгдэв.

2001 оны тунхаглалд “терроризм, салан тусгаарлах хөдөлгөөний эсрэг тэмцэнэ” хэмээн цохон тэмдэглэв.

Шанхайн гишүүн орнуудын төрийн тэргүүнүүд 2003 оны 5-р сард тус байгууллагын үүрэг, 2004 оны 4-р сард хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагааны төлөвлөгөө болон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хэтийн төлвийг тус тус тодорхойлов.

ШХАБ-ын гишүүн орнуудын 2004 оны 6-р сард болсон уулзалтын гол зорилго эдгээр орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэгдэв.

Ази тив дэх Оросын стратегийн зорилгын үүднээс харахад, олон улсын байдал улам улмаар өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд Орос улс тус бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулах мөн аюулгүй байдал болон эдийн засгийн хамтын ажиллагааны системийг бүрэлдүүлж байгаа нь өөрийн гэсэн логиктой юм. Хэдийгээр Орос олон асуудлаар АНУ-ын байр суурьтай санал нэгтэй байгаа боловч түүнд хүчин чадал, эрх мэдлийн хувьд эрх тэгш түншлэл хэрэгтэй бөгөөд чухамхүү энэ улсын хувьд Хятад улс эрх тэгш түнш нь мөн болно.

Гэвч Шанхайн байгууллагын гишүүн орнуудын дунд нэлээд зөрчил оршсоор байгаа нь тодорхой юм. Энэ нь юуны өмнө гишүүн орнуудын зүгээс Орос, Хятадад үзүүлж буй итгэл хангалтгүй байгаагаар тайлбарлагдана.

Эрт дээр үеэс төв Азийн орнууд Орос, Хятадыг аюул занал учруулагч орнууд өөрөөр хэлбэл их гүрэн хэмээн үзсээр ирсэн юм. Тухайлбал Казахстан олон улсын харилцааны судлаачдын үзэж байгаагаар Орос Казахстан хооронд оршиж буй үндсэн гол зөрчил бол Орос улс Казахстан хувьд нэг талаас аюулгүй байдлыг нь хангагч нөгөөтэйгүүр заналхийлэгч орон юм.

Шанхайн гишүүн орнуудын дунд буй болсон бас нэг зөрчил нь тус бүс нутагт өдрөөс өдөрт өсч буй Хятадын улс төр, эдийн засгийн оролцооноос эхтэй юм. Орос улс үүнд маш их сэтгэл зовниж байгаа юм. Харин Хятад өөрийн зүгээс тус бүс нутаг дахь Оросын сонирхолыг хөндөхгүй гэдгээ мэдэгдсээр байгаа билээ. Хятад, Оросын сэтгэлийг түгшээж буй нийтлэг нэг зүйл бол тус бүс нутагт Америкийн цэргийн оролцоо улам нэмэгдэж байгаа явдал юм. Хэдийгээр Шанхайн хамтын ажиллагааны байгууллага ямарваа нэгэн орны эсрэг чиглэгдээгүй боловч тус байгууллага хамтын аюулгүйн бодлогын үүднээс АНУ тус бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж байгааг тэмдэглэсээр байгаа юм. Нөгөө нэг ярвигтай асуудал бол “аюулгүйн байдал – хамтын ажиллагаа - зөрчил” гэсэн олон улсын систем бөгөөд энэ нь гишүүн орнуудын харилцаанд оршиж буй тайван бус үл итгэлцэх байдлаар тайлбарлагдана.

Тус бүс нутагт Шанхайн хамтын ажиллагааны байгууллагаас гадна хоёр хүчирхэг байгууллага байдаг бөгөөд тэдгээр нь хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага /CSTO/ Европын холбоо юм.

Эдгээрт Төв Азийн бүх орнууд хамаарагддаггүй бөгөөд тэр тусмаа Хятад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй билээ. Иймээс ирээдүйд шийдвэрлэх шаардлагатай нэг асуудал бол тус бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа нь цаашид чухам аль байгууллагатай илүү нөхцөлдөхийг тодорхойлох явдал болно. Гэвч өнөөдөр энэ асуултад хариу өгөхөд туйлын бэрх юм.

Хэдийгээр хоёр орны харилцаа 1990-ээд оноос идэвхжиж байгаа боловч Орос болон Хятадын олон улс судлаачид хоёр улсын харилцааны талаар нэлээд чухал, анхаарал татахуйц дүгнэлтийг хийсээр байгаа билээ.

Оросын судалгааны сэтгүүлүүдэд Хятадыг Оросын Төв Ази дахь гол өрсөлдөгч, Хятад эдийн засаг цэргийн хүчээр түрий барьж тус бүс нутагт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ба цаашид Орос улсыг золиослох болно гэх мэтээр бичиж байгаа билээ.

Зарим судлаачдын үзэж байгаагаар өнгөрсөн 10 гаруй жилийн дотор хоёр орны хооронд маргаантай асуудал үндсэндээ шийдэгдсэн гэдэг боловч энэ нь үнэн чанартаа тийм биш юм. Орос, Хятадын хооронд газар нутгийн маргаан байхгүй гэдгийг 2001 оны гэрээгээр нотолсон боловч Хятадын урьдын байр суурь огт өөрчлөгдөөгүй. Хятадын гол сонирхол нь Оросын Алс Дорнод юм. Хятад улс Оросын Алс Дорнодыг түүхээсээ Хятадын нутаг дэвсгэр гэж үзэх ба хэзээ нэгэн цагт Орос түүнийгээ эргүүлж өгөх ёстой ажээ. Нөгөөтэйгүүр Оросын зарим судлаачдын үзэж байгаагаар Хятад Оросын Алс Дорнодод аажмаар үйл ажиллагаагаа идэвхжүүлж улмаар энэ нутагт Хятадын хяналтыг

бий болгон өөрийн мэдэлд шилжүүлэх нь болзошгүй ажээ. Мөн тэдний үзэж байгаагаар сүүлийн жилүүдэд Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл Ази, номхон далайн бүс нутаг руу хандсан бөгөөд Орос улс энэ бүс нутагт өөрийн ноёрхлыг тогтоохоор шийдсэн ажээ.

ЗХУ задарснаас хойшхи хугацаанд Оросын гадаад улс төрийн бодлого өөрчлөгдсөөр ирсэн билээ. Эхлээд Орос улс Өрнөдийн орнууд, АНУ хийгээд Дорно дахины орнуудтай тэнцвэртэй харилцаа тогтоохыг чухалчилж байсан бол цаашдаа Өрнөдийн эсрэг холбоо байгуулахыг оролдож эхэлсэн юм. Харин Путины гадаад улс төрийн бодлогын өөрчлөлт нь Өрнөдийн орнууд ялангуяа АНУ, Ази, номхон далайн бүс нутгийн орнуудтай нягт харилцаа тогтоох явдал бөгөөд энэ нь Орос улсын гадаад бодлогын шинэ тэргүүлэх чиглэл юм.

Орос улсын Ази, номхон далайн бүс нутагт дахь стратеги бол олон улсын хамтын ажиллагааны шинэ дэгийг тогтоож тус бүс нутгийн гол гол орнуудтай сайн хөршийн харилцаа тогтоох явдал юм. Орос улс тус тивд дахин гол тоглогч болж хувирсан бөгөөд тэрээр Хятад улстай нягт харилцаа тогтоож, энэ бүс нутагт аюулгүйн байдлын системийг бэхжүүлэхийг зорьж байна.

*“Чжунгун яньцзю” сэтгүүл 2005.№2 (Тайвань)*

*Хятад хэлнээс орчуулсан: Н.Ариунгуа (Түүхийн ухааны доктор)  
Б.Хулан (ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан)*